

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ 2022 ОНЫ БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН**

2022.12.13

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны хуралдаанаар батлагдсан дүүргийн Төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааварт нийцүүлэн зохион байгуулан ажиллалаа.

1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувийн хамт ерөнхий байдлаар дүгнэн бичнэ.

2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 18377.1 мян төгрөгийн төсөвт өртөг бүхий 42 төсөл арга хэмжээг төлөвлөсөн боловч Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ буюу зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны хувьд батлагдсан төсөвт өртөг захирамжаар задарч батлагдсан, мөн төлөвлөгөөнд нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт хийсэнтэй уялдан нийт 20275.7 мян төгрөг бүхий 67 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсноор худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (мян. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	17699.4	48
2	Худалдан авах ажиллагааг он дамжуулан хэрэгжүүлж буй	215.9	4
3	Төсвийн тодотголоор хасагдсан төсөл арга хэмжээ	2360.4	15
ДҮН		20275.7	67

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 92,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснээр 250.3 мян.төг-ийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих 1174.0 мян төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (мян. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	1156.2	11
2	Төсвийн тодотголоор хасагдсан төсөл арга хэмжээ	17.8	1
ДҮН		1174.0	12

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт 100 хувь бөгөөд нийт 49,0 мян.төгрөгийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

- Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 400.0 мян төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд төсөл арга хэмжээг багцалсан бөгөөд 4 төсөл арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

д	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (мян. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	400.0	4
ДҮН		400.0	4

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт 100 хувь бөгөөд нийт 8,4 сая төгрөгийн хэмнэлт үүсгэн ажиллаа.

- Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих нийт 6189.9 мян төгрөг бүхий төсөв өртөг бүхий худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны хүрээнд батлагдсан төсөвт өртөг багцлагдан задарсантай уялдан төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж төсөл арга хэмжээний нийт тоо 27 худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр өөрчлөлт орсон. Хэрэгжилт дараах байдалтай байна.

д	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (мян. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
---	---	-------------------------	--------------------------

1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	5784.2	16
2	Худалдан авах ажиллагааг он дамжуулан хэрэгжүүлж буй	120.0	1
3	НЗД-ын А/1231 захирамжаар хүчингүй болсон	71.1	4
4	НБГ руу төсөв хянуулахаар хүргүүлсэн	214.6	6
ДҮН		6189.9	27

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт 94,1 хувь бөгөөд нийт 30,1 мян төгрөгийн хэмнэлт үүсгэн ажиллаа.

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт.

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион байгуулахаар 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 7496,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 48 төсөл арга хэмжээ ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсноор худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (мян. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	3728.8	29
2	Худалдан авах ажиллагааг он дамжуулан хэрэгжүүлж буй	350.0	1
3	ИТХ руу эрх шилжүүлсэн /Тус байгууллага өөрсдөө зохион байгуулах/	160.0	3
4	Төсвийн тодотголоор хасагдсан төсөл арга хэмжээ	3258.0	15
ДҮН		7496,8	48

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт 96,7 хувь, 57,0 мян төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт түүний хэрэгжилт

Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын хүрээнд нийт 24 үнэлгээний хороо байгуулагдсан бөгөөд 2022 онд хэрэгжүүлбэл зохих худалдан авах ажиллагааны хэрэгжилт нэгдсэн байдлаар доорх байдалтай байна.

Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт

(2022 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар)

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)		Төсөл арга хэмжээний тоо	
		Хэрэг-жүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн	Хэрэг-жүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн
1	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	17915.3	17699,4	52	48
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1156.2	1156.2	11	11
3	Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалт /НОНХС /	400.0	400.0	4	4
4	Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалт /НТХО/	5904.2	5784.2	17	16
4	Бусад эх үүсвэрээс хэрэгжсэн хөрөнгө оруулалт	4078.9	3728.8	30	29
НИЙТ ДҮН		29454.6	28768.6	114	108
Хэрэгжилт		94,7%			

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 394.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа. Хэрэгжилт 94,7 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим худалдан авах ажиллагааны журмын дагуу tender.gov.mn цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тендерийн Үнэлгээний хороодод тус албаны бүх албан хаагчид санамсаргүй байдлаар сонгогдон, нарийн бичгийн даргаар ажиллаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерийн урилга баримт бичиг болон үр дүнгийн мэдээллийг тухай бүрт цахим системээр дамжуулан ил тод, нээлттэй байршуулж иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд:

- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын 2022 оны жилийн төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан tender.gov.mn, дүүргийн sbd.gov.mn, shilendans.gov.mn report.ub.procurement.mn сайтуудад, дүүргийн худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллээ.
- 2022 оны 12 дугаар сарын байдлаар хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны мэдээ тайланг ил тод мэдээлсэн бөгөөд тендерийн үр дүнгийн мэдээллийг tender.gov.mn , shilendans.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын sbd.gov.mn , report-ubprocurement.mn вэб хуудас болон дүүргийн худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаа.

1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны хамт тусгана.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелэсэн талаархи тайлбарыг тухайн хөрөнгийн эх үүсвэрийн мэдээллийн дор бүрт нь тайлбар оруулав.

1.3 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн тухай

2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 108 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан байна. Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд бүрэн хийж захиалагчид үнэлгээний дүгнэлтийг хүргэж ажилласан болно.

1.4 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил түүнийг хэрхэн засаж залруулсан тухай /тус бүрээр/

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад зөрчил гараагүй болно.

1.5 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулахад онцгой анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2022 онд бүрэн хэрэгжүүлсэн нийт 108 төсөл арга хэмжээнээс гомдол гараагүй байна.

1.6 Чанар стандартын шаардлага хангасан дотоодыг бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах

Дотоодын бараа бүтээгдэхүүний давуу эрхийн зөрүү тооцох зорилгоор Тендерийн баримт бичигт албан хүсэлт болон нотлох баримтыг шаардаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 530.5 мян төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээнд дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон болно.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаарх дүгнэж ирүүлнэ.

Тус алба нь 2022 онд нийслэл, дүүргийн төсвийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжих нийт 29454,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 114 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаагаас 28768.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 108 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерийн системээр бүрэн зохион

байгуулаад байна. Мөн цахим тендерийн урилга, үр дүн, гүйцэтгэгчийн гэрээний мэдээллийг тухай бүрд оруулж, нийтэд ил тод нээлттэй ажиллалаа.

2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлнэ.

Захиалагчийн хувьд ерөнхий гэрээгээр хэрэгжих худалдан авалт байгаагүй тул цахим дэлгүүр ашиглаагүй болно.

ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1. Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан талаар тусгана.

Дүүргийн төсвийн харьяа 3 байгууллагын /Дүүргийн иргэдийн хурал, Дэвшил менежмент ОНӨТҮГ/ нийт 404.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Tender.gov.mn-д тусгаж нийтлэсэн.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ өгсөн тухай зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсарган ирүүлнэ.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газрыг худалдан авах ажиллагаатай холбоотой бүх талын мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиалагч болох дүүргийн Засаг даргын Тамгын газартай тус алба нь байнга хамтран ажиллаж “Худалдан авах ажиллагааны захиалгын маягт”-ын дагуу төсөл арга хэмжээ бүрийн захиалга даалгаврын хүлээн авч боловсруулан, мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаа.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ,САНАЛ

4.1. Захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлтийг тодруулан гаргаж тавина

2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 108 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны худалдан авах ажиллагааны журмын сонголт дараах байдалтай байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 67 төсөл арга хэмжээ;
- Тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар 29 төсөл арга хэмжээ;
- Зөвлөхийн бус үйлчилгээ журмаар 8 төсөл арга хэмжээ;
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт 4 тус тус зохион байгуулсан байна.

2022 оны жилийн эхний хагасын байдлаар нийт төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны зохион байгуулалт 94.7%.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 394.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллаа.

4.2. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан тухай

Гэрээний хэрэгжилтийг захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар тус тус хяналт тавьж ажиллаж байна.

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**